

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/290/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/177
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 13 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 83,3 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход

019020429

хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,583,639.92	287,815,586.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	46,607,119.01	251,725,296.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	46,607,119.01	251,725,296.19
3121	Төгрөг	46,607,119.01	251,725,296.19
31211	Төрийн сангийн харилцах	46,607,119.01	251,725,296.19
35	БАРАА МАТЕРИАЛ	60,976,520.91	36,090,289.91
351	Түүхий эд материал	13,218,761.91	13,218,761.91
35110	Тусгай зориулалттай материал	13,218,761.91	13,218,761.91
354	Хангамжийн материал	47,757,759.00	22,871,528.00
35410	Бичиг хэргийн материал	1,802,600.00	105,000.00
35420	Аж ахуйн материал	11,118,259.00	7,753,728.00
35440	Түлш, шатах тослох материал	2,200,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	12,630,000.00	00.00
35460	Хүнсний материал	1,076,200.00	2,267,700.00
35470	Бусад хангамжийн материал	18,930,700.00	12,745,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	808,002,563.73	2,364,414,020.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	808,002,563.73	2,364,414,020.57
392	Биет хөрөнгө	718,166,563.73	2,280,427,087.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	581,695,073.15	2,033,575,227.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-91,404,237.72	-114,132,797.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,450,000.00	41,450,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,746,250.12	-18,891,250.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	191,142,509.00	252,270,274.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,610,081.51	-73,992,876.54
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,818,043.20	133,035,662.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,308,043.97	-36,092,135.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,220,000.00	28,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,045,642.79	-2,275,371.41
39217	Ном	36,955,194.49	36,580,353.63
393	Биет бус хөрөнгө	89,836,000.00	83,986,933.32
39301	Програм хангамж	200,000.00	140,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	89,836,000.00	89,836,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-5,989,066.68
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	915,586,203.65	2,652,229,606.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	193,714.09	137,960.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	193,714.09	137,960.00
413	Өглөг	193,714.09	137,960.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	193,714.09	33,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	104,960.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	915,392,489.56	2,652,091,646.67
51	Засгийн газрын хувь оролцоо	915,392,489.56	2,652,091,646.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	449,939,373.00	449,939,373.00
51101	Өмч: - төрийн	449,939,373.00	449,939,373.00
512	Хуримтлагдсан үр дүн	225,772,762.34	1,962,471,919.45
51210	Өмнөх үеийн үр дүн	225,772,762.34	225,772,762.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,736,699,157.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	239,680,354.22	239,680,354.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	915,586,203.65	2,652,229,606.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,112,999,665.54	3,070,352,597.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	863,838,665.54	1,610,193,549.82
120	Нийтлэг татварын бус орлого	863,838,665.54	1,599,263,549.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	863,838,665.54	1,599,023,949.82
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,859,400.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	860,979,265.54	1,598,911,144.82
120009	Бусад орлого	00.00	239,600.00
122	Тусламжийн орлого	00.00	10,930,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	10,930,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,249,161,000.00	1,460,159,048.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	669,456,448.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	669,456,448.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,686,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,686,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	160,763,500.00	184,186,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	160,763,500.00	184,186,800.00
1330	Төсвийн захирагчдаас	1,013,710,900.00	606,515,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,013,710,900.00	606,515,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,199,486,372.01	1,333,653,440.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,199,486,372.01	1,333,653,440.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,093,434,943.99	1,333,653,440.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	753,292,237.67	861,264,666.96
210101	Үндсэн цалин	551,330,791.67	632,259,553.07
210102	Нэмэгдэл	163,850,661.30	178,251,804.01
210104	Урамшуулал	38,110,784.70	50,753,309.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,851,844.76	107,968,218.62
210201	Тэтгэврийн даатгал	56,686,847.50	73,852,332.81
210202	Тэтгэмжийн даатгал	7,320,987.27	8,688,512.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,850,069.65	6,933,209.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,453,214.58	1,578,161.51
210205	Эрүүл мэндийн даатгал	14,540,725.76	16,916,002.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,516,216.00	107,038,190.15
210301	Гэрэл, цахилгаан	2,576,126.00	4,044,013.45
210302	Түлш, халаалт	67,802,780.00	98,076,582.70
210303	Цэвэр, бохир ус	3,137,310.00	4,917,594.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,483,743.00	8,214,460.00
210401	Бичиг хэрэг	2,829,350.00	4,374,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,389,735.00	3,773,860.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,038,200.00	6,600.00
210408	Бараа материал акталсны зардал	1,226,458.00	00.00
2105	Нормативт зардал	90,720,010.00	99,364,900.00
210502	Хоол, хүнс	90,720,010.00	99,364,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,363,000.00	13,233,900.00
210604	Урсгал засвар	1,363,000.00	13,233,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,610,200.00	6,305,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,859,400.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,750,800.00	6,305,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,597,692.56	130,264,004.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,322,430.00	42,029,066.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,597,700.00	5,411,110.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,677,562.56	82,823,828.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,051,428.02	00.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	74,686,600.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,753,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	67,932,800.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,364,828.02	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,364,828.02	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	913,513,293.53	1,736,699,157.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,614,500.34	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,614,500.34	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,614,500.34	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	910,898,793.19	1,736,699,157.11

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,252,020,400.00	1,463,818,648.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,859,400.00	3,659,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,859,400.00	239,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,859,400.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,859,400.00	00.00
120009	Бусад орлого	00.00	239,600.00
122	Тусламжийн орлого	00.00	3,420,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	3,420,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,249,161,000.00	1,460,159,048.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	669,456,448.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	669,456,448.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,686,600.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,686,600.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	160,763,500.00	184,186,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	160,763,500.00	184,186,800.00
1330	Төсвийн захирагчдаас	1,013,710,900.00	606,515,800.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,013,710,900.00	606,515,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,205,413,280.99	1,254,996,720.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,205,413,280.99	1,254,996,720.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,047,707,702.97	1,200,295,070.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	744,786,525.73	862,007,771.39
210101	Үндсэн цалин	542,676,723.72	622,230,514.78
210102	Нэмэгдэл	163,577,226.60	212,833,763.74
210104	Урамшуулал	38,532,575.41	26,943,492.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,670,146.24	107,389,169.28

210201	Тэтгэврийн даатгал	60,505,548.98	73,592,930.52
210202	Тэтгэмжийн даатгал	7,320,987.27	8,631,347.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,850,069.65	6,887,497.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,453,214.58	1,640,236.13
210205	Эрүүл мэндийн даатгал	14,540,325.76	16,637,157.81
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77,441,216.00	105,933,230.15
210301	Гэрэл, цахилгаан	2,576,126.00	4,044,013.45
210302	Түлш, халаалт	71,727,780.00	97,076,582.70
210303	Цэвэр, бохир ус	3,137,310.00	4,812,634.00
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	60,000.00
2105	Нормативт зардал	38,890,660.00	43,012,350.00
210502	Хоол, хүнс	38,890,660.00	43,012,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,993,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	15,993,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,401,200.00	6,305,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,859,400.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,541,800.00	6,305,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,524,955.00	74,587,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,662,280.00	62,386,890.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,862,675.00	12,200,560.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,705,578.02	54,701,650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	126,340,750.00	54,701,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	51,654,150.00	54,701,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,753,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	67,932,800.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	31,364,828.02	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,364,828.02	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	46,607,119.01	208,821,927.18
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	46,607,119.01	208,821,927.18
9	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	46,607,119.01
10	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	46,607,119.01	251,725,296.19

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	166,707,160.81	856,326,888.03
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	166,707,160.81	856,326,888.03
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,593,774.68	11,593,774.68
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	225,772,762.34	915,392,489.56
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	225,772,762.34	915,392,489.56
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	225,772,762.34	915,392,489.56
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,736,699,157.11	1,736,699,157.11
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	449,939,373.00	239,680,354.22	1,962,471,919.45	2,652,091,646.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,262,124,870.82	1,192,609,830.82	-69,515,040.00	94.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,262,124,870.82	1,192,609,830.82	-69,515,040.00	94.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,204,580,820.82	1,137,908,180.82	-66,672,640.00	94.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	862,007,771.39	862,007,771.39	00.00	100.0
210101	Үндсэн цалин	622,230,514.78	622,230,514.78	00.00	100.0
210102	Нэмэгдэл	212,833,763.74	212,833,763.74	00.00	100.0
210104	Урамшуулал	26,943,492.87	26,943,492.87	00.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,389,169.28	107,389,169.28	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	73,592,930.52	73,592,930.52	00.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,631,347.59	8,631,347.59	00.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,887,497.23	6,887,497.23	00.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,640,236.13	1,640,236.13	00.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,637,157.81	16,637,157.81	00.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	105,933,230.15	105,933,230.15	00.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	4,044,013.45	4,044,013.45	00.00	100.0
210302	Түлш, халаалт	97,076,582.70	97,076,582.70	00.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,812,634.00	4,812,634.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	00.00	60,000.00	60,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	00.00	60,000.00	60,000.00	
2105	Нормативт зардал	43,012,350.00	43,012,350.00	00.00	100.0
210502	Хоол, хүнс	43,012,350.00	43,012,350.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,729,500.00	6,305,100.00	-3,424,400.00	64.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	3,424,400.00	00.00	-3,424,400.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,305,100.00	6,305,100.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75508800.00	12200560.00	-63,308,240.00	16.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75,508,800.00	12,200,560.00	-63,308,240.00	16.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57544050.00	54701650.00	-2,842,400.00	95.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,544,050.00	54,701,650.00	-2,842,400.00	95.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	57,544,050.00	54,701,650.00	-2,842,400.00	95.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,463,989,548.00	794,122,600.00	-669,866,948.00	54.2

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,272,568,100.00	606,515,800.00	-666,052,300.00	47.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,272,568,100.00	606,515,800.00	-666,052,300.00	47.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	184,186,800.00	184,186,800.00	00.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	184,186,800.00	184,186,800.00	00.00	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,664,000.00	00.00	-3,664,000.00	0.0
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүж	3,664,000.00	00.00	-3,664,000.00	0.0
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	3,570,648.00	3,420,000.00	-150,648.00	95.8
122001	Хандив тусламж /дотоод/	3,570,648.00	3,420,000.00	-150,648.00	95.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгд	00.00	46,607,119.01	46,607,119.01	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгд	00.00	46,607,119.01	46,607,119.01	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.00	51.00	-01.00	98.1
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	37.00	-01.00	97.4
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	00.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүйн хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 13 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 89,0 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус сургууль нь 52 орон тоо батлагдсанаас 52 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сард Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 92,3 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,736,643.4 мянган төгрөгөөр буюу 189,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	46,607.1	251,725.3	205,118.2
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	60,976.5	36,090.3	-24,886.2
Үндсэн хөрөнгө	808,002.5	2,364,414.0	1,556,411.5
Нийт хөрөнгө	915,586.2	2,652,229.6	1,736,643.4
Өр төлбөр	193.7	137.9	-55.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	915,392.5	2,652,091.6	1,736,699.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	915,586.2	2,652,229.6	1,736,643.4

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 251,725.3 мянган төгрөг өмнөх оноос 205,118.2 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн зардал болон төрийн өмчийн барилгын тогтмол зардлуудыг хэмнэж ажилласантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл байхгүй.

Бараа материал дансны үлдэгдэл 36,090.3 мянган төгрөг болж өмнөх оноос 24,886.2 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн бараа материал, бусад хангамжийн бараа материал данснаас 4,590.9 мянган төгрөгийн материалыг аж ахуйн материал данснаас, 3,486.0 мянган төгрөгийн материалыг бусад аж ахуйн материал данснаас хасаж акталсантай холбоотой байна. Мөн бараа материал шилжүүлсэнтэй холбоотой.

Үндсэн хөрөнгө данс 2,364,414.0 мянган төгрөг болж 1,556,411.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 39,553.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж болон тавилга эд хогшил, хандиваар 89,917.8 мянган төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил орлогод авсан. Тайлант онд 1,451,880.61 мянган төгрөгийн шинэ байр ашиглалтад орсныг хүлээн авсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 137.0 мянган төгрөг байгаа нь цэвэр бохир усны өртэй холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,486,401.5 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээс 441,332.1 мянган төгрөг, нийт 4,927,733.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 4,927,733.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,486,401.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,952,744.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 441,332.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 3,420.0 мянган төгрөгийг бусад орлого 334.1 мянган төгрөг нийт 975,103.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,190,050.7 мянган төгрөг буюу 125,6 хувьтай байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 976,602.0 мянган төгрөг буюу 125,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлын төсвийг 104,330.9 мянган төгрөгөөр, нормативт зардал 3,559.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 20,547.2 мянган төгрөгөөр тус тус төлөвлөгдсөнөөс илүү зарцуулсантай холбоотой байна. Энэ нь 2023 оны тодотголоор 250,864.5 мянган төгрөгийг улсын төсвөөс нэмж олгосон.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	3,253.5	3,253.5	0	100%
2	80312 Сургалт семинар	1,626.8	1,619.8	1.0	99,6%
3	81605 Эрүүл мэндийг дэмжих	3,253.5	3,250.0	3.5	99,9%
4	81801 Үдийн цай хөтөлбөр	69,061.1	57,544.0	11,517.0	83,3%

5	81806 Дотуур байрны үйлчилгээ	69,752.8	66,377.9	3,347.9	95,1
6	81816 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх	34,119.1	34,119.1	0	100%
7	81823 Мэргэжил дээшлүүлэх	7,320.4	7,183.4	137.0	98,1%
8	81827 Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	2,415.0	483.0	1,932.0	20%
9	81834 Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	974,098.3	830,484.4	143.6	85,3
10	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	157,476.7	144,032.1	13,444.6	91,5%
11	81844 Төрөлжсөн сургалт	3,570.4	3,420.0	150.7	95,8%
12	81848 Түрээсийг сурах бичиг	3,424.4	3,424.4	0	100%
13	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	184,186.6	106,933.2	77,253.5	58%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-80226	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Байр ашиглалтын үйлчилгээ 100%	3,253.5	3,253.5
2	71801-80312	2023-12-31	Сургалтын чанар сайжруулах	Сургалт семинар 99,6	1,626.8	1,619.8
3	71801-81605	2023-12-31	Урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийг дэмжих 99,9%	3,253.5	3,250.0
4	71801-81801	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Үдийн цай хөтөлбөр 83,3%	69,061.1	57,544.0
5	71801-81806	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Дотуур байрны үйлчилгээ 95,1%	69,752.8	66,377.9
6	71801-81816	2023-12-31	Хүүхэд бүрийг компьютертой болгох	Хүүхдэд ээлтэй орчин 100%	34,199.1	34,119.1

7	71801-81823	2023-12-31	Мэргэшүүлэх	Мэргэжил дээшлүүлэх 98,1%	7,320.4	7,183.4
8	71801-81827	2023-12-31	Иргэн бүрийг бичиг үсэгтэй болгох	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр 20%	2,415.0	483.0
9	71801-81834	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Стандарт сургалтын үйл ажиллагаа 85,3%	974,098.3	830,484.4
10	71801-81835	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах 91,5%	157,476.7	144,032.1
11	71801-81844	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Төрөлжсөн сургалт 95,8%	3,570.7	3,420.0
12	71801-81848	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Түрээсийн сурах бичиг 100%	3,424.4	3,424.4
13	71801-80111	2023-12-31	Үндсэн үйл ажиллагаа	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал 56,0%	184,186.8	106,933.2

Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны үйлчилгээ арга хэмжээнүүд дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн. Бичиг үсгийн боловсрол арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь хамрагдах хүүхдийн тоо муу ирц хангалтгүйгээс дутуу хэрэгжсэн байна.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь томуу томуу төст өвчин ихэссэн, ЕБС цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс нийт 34,119.1 мянган төгрөгийн лаптоп 12 ширхэг, принтер 2 ширхэг, таблет 3 ширхэг, спикер 1 ширхэг, сандал 5 ширхэг, мемори карт 1 ширхэг, пос машин 1 ширхэг тус тус худалдан авалт хийсэн байна. Цахим анги тохижуулахад Саммит компьютер технологи ХХК, Техно зон ХХК–иас зөөврийн компьютер болон таблет авах цахим худалдан авалт хийгдсэн. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 02 дүгээр сарын 11-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,170,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 23,400.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 18,720.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Бүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 12 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 3,424.4 мянган төгрөгөөр
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 63,308.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 156 мэдээллийг байршуулж 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүнба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Бүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр тусгав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	382.4	1	382.4	100,0
Албан шаардлага	3	26,975.8	3	26,975.8	100%
Зөвлөмж	1	1,384.2	1	1,384.2	100%
Нийт дүн	5	28,742.4	5	28,742.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татхуйц асуудал ажиглагдсангүй.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,443.4 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1,092.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 351.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн тайланг шалгахад 2023 онд шинээр ашиглалтад ороогүй байсан барилгын засварт гэж бичээд 1,092.0 мянган төгрөгийн зардал гаргасан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай байхаар төсөвлөж зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

1.Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Хүнсний бүтээгдэхүүний зарцуулалтыг шалгахад батлагдсан жишиг нормыг баримталж ажиллаагүйгээс 351.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/166 дугаартай хамтарсан тушаалын 3-р хавсралтыг мөрдөж ажиллах гэсэн тушаалын заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид дээрх тушаалд дурдсан батлагдсан орц нормыг баримталж ажиллах

Дээрх төлбөрийн акт болон зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шинээр ашиглалтанд орсон барилгыг дансанд аваагүй. Гэтэл 1,092.0 төгрөгийн зарлага гаргасан	1	1,092.0	1	1,092.0								
Хоногт хэрэглэх хүнсний нормыг батлуулаагүй харилцан адилгүй зарцуулсан	1	351.1					1	351.1				
Дүн	2	1,443.4	1	1,092.0			1	351.1				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 3 мэдээлэл хоцроож байршуулсан	1							1
Дүн	1							1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn